Дээрх хүснэгтээс харахад нөлөө бүхий өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөг, засгийн газрын оролцоо данснууд байна. Тухайлбал:

Авлага дансны үлдэгдэл 237,708.3 мянган төгрөг болж, 149,309.4 мянган төгрөгөөр өссөн нь Сангийн яам үйл ажиллагааны орлогоос төвлөрүүлсэн 205,380.2 мянган төгрөг, тайлант онд гэрээгээр ажил гүйцэтгэсэн 4,950.0 мянган төгрөгийн авлагаар тус тус нэмэгдэж, 61,020.8 мянган төгрөгийн авлага барагдсантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 363,269.1 мянган төгрөг болж, 26,202.6 мянган төгрөгөөр өссөн нь байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулах, музейн үзмэр, үзүүлбэрүүдийг засаж сэлбэх, дэглэх, үйлчилгээний чанарыг сайжруулахад зориулан 120,434.3 мянган төгрөгийн бараа материал орлогод авч, 94,231.7 мянган төгрөгийн бараа материал зарцуулсан зэргээс голлон шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 8,182,996.0 мянган төгрөг болж, 132,290.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд Захирлын А/73, А/81 тушаалуудаар 12,530.0 мянган төгрөгийн түүх, соёлын дурсгалт зүйлсийг өөрийн хөрөнгөөр бүтээн үнэ төлбөргүй орлогоор хүлээн зөвшөөрсөн, ТӨБЗГ-ын 2025 оны А/493 дугаар албан бичгээр 15,000.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгслийг үнэ төлбөргүй хүлээн авсан, “И номин” ХХК-иас 5

нэр төрлийн 10,540.0 мянган төгрөгийн өнгөт принтер, зөөврийн компьютер хандиваар авсан, төсвийн хөрөнгөөр 10,094.7 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан, тайлант онд 180,455.2 мянган төгрөгийн мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал байгуулсантай тус тус холбоотой байна.

Өглөг дансны үлдэгдэл 64,550.2 мянган төгрөг болж, 62,735.1 мянган төгрөгөөр өссөн нь Сангийн яамнаас эрх нээж өгөөгүйгээс шалтгаалан Нийгмийн даатгалын хэлтэст төлөх 8,806.0 мянган төгрөгийн шимтгэл, Үндэсний аудитын газарт төлөх 5,000.0 мянган төгрөгийн аудитын төлбөр, Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн үзлэгийн 6,784.0 мянган төгрөгийн төлбөр, “УБЦТС” ТӨХК-д цахилгааны 7,988,3 мянган төгрөгийн төлбөр, Чингэлтэй дүүргийн татварын хэлтэст төлөх 1,440.0 мянган төгрөгийн хог хаягдлын төлбөр болон бусад харилцагч байгууллагуудад өгөх 32,716.8 мянган төгрөг өр төлбөр үүссэн байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 8,720,877.4 мянган төгрөг болж 19,513.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацааны үр дүнгээс шалтгаалжээ.

Байгалийн түүхийн музей нь Санхүүгийн тооцоолох групп ХХК-ийн патент бүхий Acolous нягтлан бодох бүртгэлийн программыг ашигладаг. Нийт ажил үйлчилгээ болон программын нэвтрүүлэлтийн төлбөр жилд 110.0 мянган төгрөг бөгөөд энэ үнэнд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой шинэчлэлт, сайжруулалтыг цаг алдалгүй хийдэг байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус музейн 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,280,976.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 2,280,976.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 92,182.0 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 7,030.0 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой зардлыг 33,386.0 мянган төгрөг, хангамж бараа материалын зардлыг 39,024.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 18,227.1 мянган төгрөг, бусад төрлийн зардлыг 11,998.6 мянган төгрөг, нийт урсгал зардлыг 201,847.7 мянган төгрөгөөр бууруулж, 2,079,128.7 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант оны батлагдсан төсвийг 201,847.7 мянган төгрөгөөр бууруулж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,079,128.7 мянган төгрөгийг улсын төсвөөс, 360,153.0 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

#### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,932,487.1 мянган төгрөгийн санхүүжилт авч урсгал үйл ажиллагаанд 1,893,906.1 мянган төгрөгийг зарцуулж, 38,581.2 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,893,906.1 мянган төгрөг буюу 91.1 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардал болон ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 37,147.0 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардлыг 926.5 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардлыг 51,033.8 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрийг 9,942.3 мянга, бараа

үйлчилгээний бусад зардлыг 29,793.2 мянган төгрөг, бусад урсгал шилжүүлгийг 56,379.8 мянган төгрөг, нийт 185,222.6 мянган төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт /хувь/
	Код	Нэр				
1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	1,814,244.6	1,766,229.0	48,015.6	97.4
2	80215	Эрдэм шинжилгээ, судалгааны ажил	3,000.0	3,000.0	-	100.0
3	80219	Харуул хамгаалалтын зардал	24,941.3	24,941.3	-	100.0
4	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	57,620.1	57,620.1	-	100.0
5	81569	Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх	420.0	420.0	-	100.0
6	81855	Гүйцэтгэлд суурилсан санхүүжилт	129,046.9	28,862.9	100,184.0	22.4
7	81938	Музейн үзмэртэй шууд харьцах албан тушаалтанд төрөөс үзүүлэх дэмжлэг	49,855.8	12,832.8	37,023.0	25.7
<b>71702</b>	<b>Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх арга хэмжээ</b>		<b>2,079,128.7</b>	<b>1,893,906.1</b>	<b>185,222.6</b>	<b>91.1</b>

Төрийн аудитын байгууллагаас Төсвийн тухай хуулийн дагуу хийх 2025-2026 оны санхүүгийн тайлан, Төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу судалгаа авч үр дүнг нэгтгэн дүгнэлээ. Үүнд:

*Бүтэц орон тоо:* Улсын Их Хурлын 54 дүгээр тогтоолын 1 дэх хэсэгт заасныг хэрэгжүүлж, төсөвт байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгаж оновчтой болгох, төрийн үйлчилгээний цахимжилтыг эрчимжүүлэх, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө”-нд туссан багш, эмч нараас бусад төрийн албан хаагчийн орон тоог 9 хувиар бууруулах арга хэмжээний хүрээнд 2025 оны 9 сарын 30-ны өдрөөр тасалбар болгон жолооч 1, цахилгаанчин 1, мужаан 1, үзмэр харгалзагч 1, зохион байгуулагч 1, нийт 5 орон тоог цомхотгож ажилласан байна.

*Хоол, унааны хөнгөлөлт:* Байгалийн түүхийн музейн захирлын 2025 оны А/29 дугаар тушаалаар хоолны хөнгөлөлтийг өдрийн 17.0 мянган төгрөгөөр, унааны хөнгөлөлтийг өдрийн 1.0 мянган төгрөгөөр баталжээ. Тайлант онд унаа, хоолны хөнгөлөлтийн зардалд 201,440.5 мянган төгрөг батлагдсан, гүйцэтгэлээр 189,340.1 мянган төгрөгийг зарцуулсан.

Байгалийн түүхийн музей нь тайлант онд хэвлэл мэдээллийн байгууллагатай ажил, үйлчилгээний гэрээ байгуулаагүй, төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал гараагүй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

**3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд үндсэн үйл ажиллагааны хүрээнд 354,945.2 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилтийн орлогыг бүрдүүлжээ.

Нэмэлт төсвийн санхүүжилтээр 5-н төрлийн арга хэмжээг санхүүжүүлсэн байна.

Мөнгөн хөрөнгийн 20.6 мянган төгрөгийн үлдэгдэл болон 354,945.1 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилтийн орлогоос хангамж, бараа материалын зардалд 43,297.4 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 10,324.7 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрийг 44,032.7 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 10,239.5 мянган төгрөг, бусад урсгал шилжүүлэгд 41,670.0 мянган төгрөг, нийт 149,564.3 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 205,380.8 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлж, 20.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

#### **4. АУДИТЫН ТАЙЛАН**

##### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Байгалийн түүхийн музейн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, анхан шатны баримт материалыг бүрдүүлж байх болон дотоод хяналтыг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Мэдээлэл-Аудит ХХК-ийн ахлах аудитор Д.Туяа, аудитор Ц.Отгонжаргал, аудитор Н.Пүрэвсүрэн нар гүйцэтгэж, чанарын хяналтын менежер А.Гэрэлмаа, захирал Д.Товуудорж нар анхан шатны чанарын хяналтыг, Санхүүгийн аудитын газрын аудитор Э.Цэлмэгбаяр, аудитын менежер И.Эрдэнэцэцэг, газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Байгалийн түүхийн музейн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 27 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

##### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн 2,392,052.1 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 23,920.5 мянган төгрөгөөр, ...тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

##### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор, ажилтан, албан тушаалтнууд гадаад, дотоод албан томилолтоор ажиллаагүй, түлш халаалт, бичиг хэрэг, багаж, техник хэрэгсэл худалдан авах зэрэг зардалд хэмнэлт гаргасан.

##### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 17 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны цахим хуудсанд 5 сая төгрөгөөс дээш орлогын 651,341.9 мянган төгрөгийн 16 гүйлгээ, зарлагын 207,373.5 мянган төгрөгийн 7 гүйлгээг тус тус мэдээлээгүй, 5 мэдээллийн хугацааг хоцроож байршуулсан.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 “Мэдээлэл үнэн зөв бодитой, иж бүрэн байх”, 4.1.3 “Тогтоосон хугацаанд, тогтмол шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.4 “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд мэдээлээгүй зөрчлийг зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага өгөхөөр шийдвэрлэлээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, мөнгөн хөрөнгө, цалин хөлс, засгийн газрын хувь оролцоо данс болон шилэн мэдээлэл данстын хувьд горим, сорил хэрэгжүүлсэн.

Аудитын илрүүлэлтийг шалгагдагч байгууллагад танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажууллаа. Завсрын аудитаар 7,226,625.4 мянган төгрөгийн 6 асуудлыг илрүүлж, асуудлын бүртгэлээр зөвлөмж өгсөн ба жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад 3 асуудлыг залруулсан, 2,621.1 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, шилэн дансны мэдээлэлтэй холбоотой зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар нийт 186,122.5 мянган төгрөгийн 9 зөрчил илрүүлснээс 126,433.9 мянган төгрөгийн зөрчлийг хууль хяналтын байгууллагад шилжүүлэхээр Шийдвэрийн хэрэгжилтийн газарт хүргүүлээд хэрэгжих шатандаа явагдаж байгаа, 11,417.0 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоосноос 11 хувийн биелэлттэй байгаа бөгөөд өмнөх удирдлагатай холбоотойгоор авлагаар бүртгэн үе шаттайгаар төлбөрийг барагдуулж байгаа, 3 албан шаардлага болон 1 зөвлөмжийг бүрэн биелүүлсэн нийт төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлт 55.5 хувьтай байна.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	3	126,433.9	0	-	-
Төлбөрийн акт	2	11,417.0	1	1,297.0	11.0
Албан шаардлага	3	48,271.6	3	48,271.6	100.0
Зөвлөмж	1	-	1	-	100.0
<b>Нийт дүн</b>	<b>9</b>	<b>186,122.5</b>	<b>5</b>	<b>49,568.6</b>	<b>55.5</b>

/мянган төгрөгөөр/

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Монгол улсын засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн “Музейн талаар авах арга хэмжээний тухай” 244 дугаар тогтоолын хэрэгжилтийг дараагийн аудитаар авч үзэх шаардлагатай гэж үзлээ.

#### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой 7,025,827.3 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

*Залруулсан алдаа:*

- Төсвийн гүйцэтгэлийн тайланг 166,258.3 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан;
- Санхүүгийн тайлан дахь засгийн газрын хувь оролцоо нь Улсын бүртгэлийн гэрчилгээнд бүртгэгдсэн өөрийн хөрөнгийн хэмжээнээс 6,859,569.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан нь УСНББОУС 1 "Санхүүгийн тайлангийн толилуулга", Санхүүгийн тайлагналын "иж бүрэн байх", "тохиолдсон байх" батламж мэдэгдлийг тус тус хангахгүй байна.

Аудитаар нийт 39,563.4 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup>, 2,621,1 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 36,942,3 мянган төгрөгийн 4 зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 39,563.4 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг түвшин 23,920.5 мянган төгрөгөөс их байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

#### 5.1 Төлбөрийн акт

*Илрүүлэлт:*

Нийгмийн даатгалын хэлтэст 2,621.1 мянган төгрөгийн акт, алдангийг байгууллагаас төлсөн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “*үнэн зөв байх*”, 18 дугаар зүйлийн 18.1-д “*Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ*” гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын "нийцсэн бөгөөд зохистой байх", “эрх ба үүрэг” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Зориулалт бусаар зарцуулсан мөнгөн хөрөнгийг буруутай албан тушаалтнаар төлүүлж, төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

#### 5.2 Албан шаардлага

##### 1. Бараа үйлчилгээний арга хэмжээний зардал данстай холбоотой асуудал

*Илрүүлэлт:*

Бараа үйлчилгээний бусад арга хэмжээний зардлаас цахилгааны зардалд 2,368.4 мянган төгрөг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*” гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын "нийцсэн бөгөөд зохистой байх", “эрх ба үүрэг” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Зардлын ангилал зөрчин төсвийг зориулалт бусаар зарцуулдаг зөрчлийг таслан зогсоох, зөрчлийг давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүлэв.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## **2. Анхан шатны баримттай холбоотой асуудал**

### Илрүүлэлт:

Мөнгөн хөрөнгийн данснаас нийт 34,229.0 мянган төгрөгийн зарлагын 27 ажил гүйлгээг анхан шатны баримтын бүрдэл дутуу гүйлгээ хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.*”, 13.7-д “*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*” гэж заасантай нийцэхгүй.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтын бүрдэл дутуу гүйлгээ хийдэг зөрчлийг зөрчлийг давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүлэв.

## **3. Бараа материалын данстай холбоотой асуудал**

### Илрүүлэлт:

Бараа материалын үлдэгдэлд аудитын биет горим хэрэгжүүлэхэд нэг бүр нь 230 төгрөгийн үнэтэй 1500 ширхэг 345.0 мянган төгрөгийн том хүний тасалбар илүү тоологдсон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “*үнэн зөв байх*”, 13 дугаар зүйлийн 13.1-д “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.*”, 18 дугаар зүйлийн 18.1-д “*Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ*” гэж заасантай нийцэхгүй байна.

### Шийдвэрлэсэн нь:

Бараа материалын үлдэгдлийн тооцоог сар бүр хийж баталгаажуулдаггүй, хяналт хэрэгжүүлдэггүй зөрчлийг давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүлэв.

Дээрх төлбөрийн актын биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны дотор, зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### 6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Төсвийн гүйцэтгэлийн тайланг 166,258.3 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан.	1	166,258.3					1	166,258.3				
2	Санхүүгийн тайлан дахь засгийн газрын хувь оролцоо нь Улсын бүртгэлийн гэрчилгээнд бүртгэгдсэн өөрийн хөрөнгийн хэмжээнээс 6,859,569.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан.	1	6,859,569.0					1	6,859,569.0				
<b>Дүн</b>		<b>2</b>	<b>7,025,827.3</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>7,025,827.3</b>				

### 6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Дд	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
1	Нийгмийн даатгалын хэлтэст 2,621.1 мянган төгрөгийн акт, алдангийг байгууллагаас төлсөн.	1	2,621.1	1	2,621.1								
2	Бараа үйлчилгээний бусад арга хэмжээний зардлаас 2,368.3 мянган төгрөгийг цахилгааны зардалд зориулалт бусаар зарцуулсан.	1	2,368.3			1	2,368.3						
3	Мөнгөн хөрөнгийн 34,229.0 мянган төгрөгийн зарлагын 27 ажил гүйлгээг анхан шатны баримтын бүрдэл дутуу гүйлгээ хийсэн.	1	34,229.0			1	34,229.0						
4	Бараа материалын үлдэгдэлд аудитын биет горим хэрэгжүүлэхэд нэг бүр нь 230 төгрөгийн үнэтэй 1500 ширхэг 345.0 мянган төгрөгийн том хүний тасалбар илүү тоологдсон.	1	345.0			1	345.0						
<b>Дүн</b>		<b>4</b>	<b>39,563.4</b>	<b>1</b>	<b>2,621.1</b>	<b>3</b>	<b>36,942.3</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>			

### 6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Д/д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
				Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>							
1	Шилэн дансны цахим хуудсанд 16-орлогын 651,341.9 мянган төгрөгийн гүйлгээ, 7-зарлагын 207,373.5 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ мэдээлээгүй, 5-н мэдээллийн хугацааг хоцроож байршуулсан байна.	1	858,715.4	1	858,715.4		
<b>Дүн</b>		<b>1</b>	<b>858,715.4</b>	<b>1</b>	<b>858,715.4</b>	<b>-</b>	<b>-</b>



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 535/АД150122

Улаанбаатар хот

САГ-2026/20/НА-СТА-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Байгалийн түүхийн музейн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Мөнгөн хөрөнгийн данснаас нийт 34,228,991.69 (гучин дөрвөн сая хоёр зуун хорин найман мянга есөн зуун ерэн нэгэн төгрөг жаран есөн мөнгө) төгрөгийн зарлагын 27 ажил гүйлгээг анхан шатны баримтын бүрдэл дутуу гүйлгээ хийсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Анхан шатны баримтын бүрдэл дутуу гүйлгээ хийдэг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Байгалийн түүхийн музейн Захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Н.Манчук), Ерөнхий нягтлан бодогч (Х.Чинзориг) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТӨРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
МЭДЭЭЛЭЛ-АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ  
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ

Д.ТОВУУДОРЖ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 536/A0150122

Улаанбаатар хот

САГ - 2026/20/НА - СТА - ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Байгалийн түүхийн музейн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бараа материалын үлдэгдэлд аудитын биет горим хэрэгжүүлэхэд нэг бүр нь 230 төгрөгийн үнэтэй 1500 ширхэг 345,000.00 (гурван зуун дөчин таван мянган) төгрөгийн том хүний тасалбар илүү тоологдсон нь санхүүгийн тайлангийн оршин байх батламж мэдэгдлийг хангаагүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Бараа материалын үлдэгдлийн тооцоог сар бүр хийж баталгаажуулдаггүй, хяналт хэрэгжүүлдэггүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Байгалийн түүхийн музейн Захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Н.Манчук), Ерөнхий нягтлан бодогч (Х.Чинзориг) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРТҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
МЭДЭЭЛЭЛ-АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ  
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ  
Д.ТОВУУДОРЖ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг-1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-79.Docx

1526180992



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 537/А0150122

Улаанбаатар хот

САГ-2026/20/НА-СТА-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Байгалийн түүхийн музейн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бараа үйлчилгээний бусад арга хэмжээний зардлаас 2,368,346.75 (хоёр сая гурван зуун жаран найман мянга гурван зуун дөчин зургаан төгрөг далан таван мөнгө) төгрөгийг цахилгааны зардалд зориулалт бусаар зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.6-д "төсвийг зориулалт бусаар зарцуулсан" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Төсвийг зориулалт бусаар зарцуулдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор **Үндэсний аудитын газарт** ирүүлэх
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Байгалийн түүхийн музейн Захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Н.Манчук), Ерөнхий нягтлан бодогч (Х.Чинзориг) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
МЭДЭЭЛЭЛ-АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ  
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ  
Д.ТОВУУДОРЖ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 534/АД150122

Улаанбаатар хот

САГ-2026/20/НА-СТА-ТШЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Байгалийн түүхийн музейн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим хуудсанд 5 сая төгрөгөөс дээш орлогын 651,341,950.00 (зургаан зуун тавин нэгэн сая гурван зуун дөчин нэгэн мянга есөн зуун тавин) төгрөгийн 16 гүйлгээ, зарлагын 207,373,460.32 (хоёр зуун долоон сая гурван зуун далан гурван мянга дөрвөн зуун жаран төгрөг гучин хоёр мөнгө) төгрөгийн 7 гүйлгээг тус тус мэдээлээгүй, 5 мэдээллийн хугацааг хоцроож байршуулсан.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 "Мэдээлэл үнэн зөв бодитой, иж бүрэн байх", 4.1.3 "Тогтоосон хугацаанд, тогтмол шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, хуулийн хугацааг мөрдөж зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Байгалийн түүхийн музейн Захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Н.Манчук), Ерөнхий нягтлан бодогч (Х.Чинзориг) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТӨРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
МЭДЭЭЛЭЛ-АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ

Д.ТОВУУДОРЖ



Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тайруу-3 Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-79.Docx

1526180994



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 114/А0150122

Улаанбаатар хот

САГ-2026/20/НА-СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Байгалийн түүхийн музейн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нийгмийн даатгалын хэлтэст 2,621,056.50 (хоёр сая зургаан зуун хорин нэгэн мянга тавин зургаан төгрөг тавин мөнгө) төгрөгийн акт, алдангийг байгууллагаас төлсөн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 18 дугаар зүйлийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.6-д “эрх бүхий этгээдээс тогтоосон норм, нормативыг хэтрүүлэн зарцуулсан” гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулан Нийгмийн даатгалын шимтгэлийг буруу тайлагнасантай холбоотой тогтоосон акт, алдангид төлсөн 2,621,056.50 төгрөгийг шийдвэр гаргасан Тооцорны нягтлан бодогчоор ажиллаж байсан Х.Чинзоригоор төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан Аудитын шалгалтын орлого 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах;
3. Актын биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Байгалийн түүхийн музейн Захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Н.Манчук)-т хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООХ НЬ:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
МЭДЭЭЛЭЛ-АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ  
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ  
Д.ТОВУУДОРЖ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264230

Z:\Akt\2026\0225 SAG-54.Docx

1526160561